



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

**2020 оны 5-р сарын 16-аас
5-р сарын 22-ны байдлаар**

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 5-р сарын 16-аас 5-р сарын 22-ны байдлаар

КОВИД-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн арав дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Фитч агентлагаас** дэлхийн эдийн засаг 2020 онд 3.2 хувиар агших төсөөллийг 5-р сард гаргав. Энэ нь өмнөх сарын төсөөллөөс 1.5 нэгж хувиар муудсан төсөөлөл юм.
- Oxford Economics байгууллагаас **дэлхийн эдийн засаг 2020 оны II улиралд хүчтэй унаж, оны сүүлийн хагасаас сэргэснээр 2020 онд 4.8 хувиар агших¹** төсөөллийг шинэчлэн гаргалаа. Төсөөлөл өмнөх сарын төлөвөөс муудахад АНУ, Европын өсөлтийн төлөв муудсан нь нөлөөлжээ. Улс орнуудын ДНБ-ий гүйцэтгэлээс харахад дэлхийн эдийн засаг 2020 оны эхний улиралд 3 хувиар агших төлөвтэй гэж тооцож байна.

Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд

	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	2020 он				
			Дэлхийн эдийн засгийн өсөлт	Хятадын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүс өсөлт	ОХУ-ын өсөлт
1	Bloomberg	5/18/2020		2.0%	-5.4%	-7.5%	-5.0%
2	Fitch	5/18/2020	-3.2%	1.1%	-4.9%	-6.7%	
3	Oxford Economics	5/18/2020	-4.8%				

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудаснууд

- КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр дэлхий даяар нэн ядуу хүний тоо 60 гаруй саяд хүрэхээр байгаа бөгөөд улс орнуудын одоогоор хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүчин чармайлт хангалтгүй байгааг Дэлхийн Банкны Ерөнхийлөгч Дэвид Мэлпасс онцоллоо. Дэлхийн банкнаас дэлхийн эдийн засаг 2020 онд 5 хүртэл хувиар агшина хэмээн төсөөлж байгаагын дээр ирэх 15 сарын туршид

ядуу буурай орнуудад нийт 160 тэрбум ам.долларын буцалтгүй тусламж болон бага хүүтэй зээл олгохоор төлөвлөөд байна.

- ХБНГУ-ын Канцлер Ангела Меркель болон БНФУ-ын Ерөнхийлөгч Имануэль Макрон нар видео бага хурал хийж хэлэлцсэний үндсэн дээр 2 улсын Засгийн газар **Европыг “Хөл хорионы их хямрал”-аас аврахын тулд 500**

¹ Тус байгууллагаас 4-р сард дэлхийн эдийн засаг 2020 онд 2.8 хувиар буурахаар төсөөлж байсан.

тэрбум еврогийн төсвийн дэмжлэг үзүүлэхээ мэдэгдлээ. Тус төсвийг КОВИД-19 цар тахалд хамгийн ихээр нэрвэгдсэн орнуудын эмзэг салбаруудыг дэмжихэд зарцуулахаар төлөвлөөд байна. Төсвийн дэмжлэгийг бүсийн орнуудын нөхцөл байдлаас хамааран буцалтгүй тусламж хэлбэрээр олгохоор заасан байгаа ч, Европын Холбооны 27 гишүүн орны зарим удирдагчид санал зөрөлдөж, эргэн төлөгдөх зээлийн нөхцөлөөр олгох хэрэгтэй гэж үзэж байгаа аж.

- **Холбооны нөөцийн банк (ХНБ)-ны тэргүүн Жером Повелл АНУ-ын эдийн засаг сэргэхэд тодорхой хугацаа шаардлагатай боловч, дунд урт хугацааны төлөв өөдрөг байгааг онцлов.** Тэрээр “Цар тахлын 2 дахь давлагаа эхлэхээс сэргийлж чадвал энэ оны II хагасаас эдийн засаг сэргэж эхэлнэ. Бодлогын арга хэмжээ байгаа оновол ирэх оны эцэс гэхэд бүрэн сэргэнэ” гэж мэдэгдлээ. Гэхдээ эдийн засгийн сэргэлт ямар хэлбэртэй байх, бизнес хэвийн үйл ажиллагаандаа эргэж орох эсэх нь вирусийг хэрхэн хяналтад оруулахаас хамаарах бөгөөд одоогоор тодорхой бус байдал өндөр байгааг дурдав. КОВИД-19 эхлэх үед Америкийн эдийн засаг эрүүл, банкны тогтолцоо хэвийн байсныг онцлоод энэ удаагийн хүндрэл 1930-оны Их хямралтай харьцуулахад “суурь ялгаа ихтэй” гэдгийг онцлов.
- **АНУ-ын Конгрессийн төсвийн алба (Congressional budget office)-наас 5-р сарын 19-ний өдөр Америкийн эдийн засаг 2-р улиралд 38% агших төсөөллийг зарлав.** Төсвийн алдагдал 2020 онд ДНБ-ий 11%-д хүрнэ гэсэн байна. Эдийн засаг оны 2-р хагаст сэргэж эхэлнэ гэсэн таамаглалыг дэвшүүлжээ.
- ОУВС-гийн тэргүүн К.Георгиева **дэлхийн эдийн засгийн төлөвийг**

ОУВС 4-р сард хийсэн төсөөллөөсөө бууруулах эрсдэл өндөр байгааг онцлов. Хэдийгээр Азийн зарим орнуудад гүйцэтгэл хүлээлтээс өндөр байгаа хэдий ч, гол эдийн засгуудад хүчтэй хөл хорио хэрэгжиж, эдийн засгийн үзүүлэлтүүд хурдтай муудсан тул өсөлтийн төсөөллийг бууруулах эрсдэл нь давамгайлж байна.

- **АНУ болон БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн ширүүсэх төлөвтэй боллоо.** КОВИД-19 вирусийн анхны тархалттай холбоотой хоёр талын маргаанаас гадна АНУ-ын Засгийн газар өнгөрсөн 7 хоногт Хятадын технологийн компаниуд болох Huawei, ZTE-д экспортын хориг тогтоож, Huawei компанийг АНУ-ын програм хангамжийг ашиглахыг хориглох шийдвэрийг гаргасан зэрэг нь нөхцөл байдал хурцдахад хүргээд байна. Түүнчлэн КОВИД-19-ийн гарал үүсэлтэй холбоотой маргаанд хариу үйлдэл болгон БНХАУ нь Австрали улсаас авах арвай зэрэг хүнсний бүтээгдэхүүний импортод татвар ногдуулснаар 2 улсын хоорондын харилцаа мөн таагүй болоод байна.
- **ОХУ-ын Засгийн газар 5-р сарын 20-нд төсвийн тэлэх багц бодлогоо санхүүжүүлэх зорилгоор 112 тэрбум рублийн Засгийн газрын бондыг арилжаалав.** Энэ нь тус улсын хувьд нэг удаагийн арилжаагаар авсан хамгийн их хэмжээний өрийн түвшин юм. ОХУ-ын 4-р сарын төсвийн үзүүлэлтүүдэд суурилан тус эдийн засаг 4-р сард 25 хувиар агшсан, II улиралд 16 хувиар агших төлөвтэй гэж Блүүмбергийн эдийн засагчид тооцож байна.
- **ХБНГУ-ын хөрөнгө оруулагчдын дунд явуулсан “The Zew”-ийн санал асуулгаар тус улсын эдийн засаг хөл хориогоо сулруулж, их хэмжээний**

төсвийн багц арга хэмжээ (ДНБ-ий 30 хувьтай тэнцэхүйц) авсны нөлөөгөөр 2020 оны II хагасаас эхлэн **сэргэх хүлээлттэй байна**. Бодит эдийн засгийн идэвхжилийг хэмжих үзүүлэлтүүд болох хурдны зам ашиглалтын төлбөр, цахилгааны хэрэглээ, олон нийтийн тээвэр хэрэглэгчдийн тоо, дэлгүүр, худалдааны төвүүдээр үйлчлүүлэгчдийн тоо зэргээс харахад хөл хориог сулруулсны дараагаас Германы эдийн засаг хурдтай сэргэх төлөв ажиглагдаж байна. “The Zew”-ийн эдийн засгийн хандлагын үзүүлэлт 5-р сард өмнөх сараас 22.8 нэгжээр буюу сүүлийн 5 жилийн дээд хэмжээгээр өсч 51 болжээ.

- **Италийн Засгийн газраас** эдийн засгийг дэмжих **55 тэрбум еврогийн төсвийг** өнгөрсөн долоо хоногт **баталлаа**. Тус төсөвт хөл хорионы улмаас дампуурлын ирмэгт тулсан бизнесүүдийг эргэлтийн хөрөнгөөр хангах (үүнд компаниудад олгох шууд

дэмжлэг бүхий 15 тэрбум евро), иргэдэд амьжиргааны мөнгөн тусламж үзүүлэх, ажилгүйдлийн тэтгэмж (25.6 тэрбум евро), эрүүл мэндийн салбарт нэмэлт тусламж (3.2 тэрбум евро) зэргийг хуваарилахаар тусгажээ. Италийн эдийн засгийн өсөлт 2020 онд 8 хувиар агшиж, төсвийн алдагдал ДНБ-ий 10.4 хувь, улсын өр ДНБ-ий 156 хувьтай тэнцүү байхаар төсөөлж байна.

- **Япон улсын ДНБ I улиралд 3.4 хувиар агшлаа**. Үүнд КОВИД-19 цар тахлаас сэргийлж хөл хорио тогтоосноос үүдэн хэрэглээ буурч, гадаад эрэлт саарснаар экспорт багассан нь голлон нөлөөлжээ. НӨАТ нэмэгдсэн болон далайн хар салхины нөлөөгөөр Японы эдийн засаг өнгөрсөн оны IV улиралд 7.3 хувиар агшаад байсан юм. II улиралд уналт гүнзгийрч, эдийн засаг 21.5 хувиар агшина гэж эдийн засагчид таамаглаж байна.

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- КОВИД-19-ийн улмаас 3 сар хойшлоод байсан Хятадын Ардын их хурал 5-р сарын 22-ны өдөр ээлжит хурлаа эхлүүлж, 2020 оны эдийн засгийн гол зорилтуудыг хэлэлцэв. 2020 оны хувьд эдийн засгийн өсөлтийн тоон зорилт тавиагүй бөгөөд, төсвийн бодлого далайцтай тэлэх, харин мөнгөний бодлого уян хатан байхаар байна. Төсвийн алдагдал өмнөх онд ДНБ-ий 2.8% байсан бол 2020 онд нэмэгдэж 3.6%-д хүрэхээр байна. Эдийн засгийг дэмжих багц арга хэмжээний хүрээнд ААН-ийн татварын хөнгөлөлтийг 2.5 их наяд юань, КОВИД-19-ийн эсрэг тусгай зориулалттай бондыг 1 их наяд юань, мөн орон нутгийн бондын квотыг 3.75 их наяд юань байхаар тогтоов. Мөн батлан хамгаалахын зардал 2020 онд 6.6 хувиар өсөхөөр байна. Инфляцийн зорилтыг 3.5 хувь гэж тогтоосон бөгөөд эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч мөнгөний уян хатан бодлого явуулна гэдгийг мэдэгдэв.
- Хятадын хот суурин газрын ажилгүйдлийн түвшин 3-р сард 5.9 хувь байсан бол, 4-р сард 6 хувьд хүрсэн талаар Үндэсний Статистикийн газраас мэдээлэв. Энэ нь оны 2-р хагаст төсөв, мөнгөний дэмжлэг үргэлжлэх шаардлагатайг илэрхийлж байна.
- Хятадын эх газрын жижиглэн худалдааны өсөлт 5, 6-р саруудад нэмэгдэх хүлээлттэй байна. Жижиглэн худалдаа оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурсан хэдий ч, 5 болон 6 сард тус тус 5 хувиар нэмэгдэх төсөөллийг Блүүмбергийн шинжээчид танилцууллаа. Хятадын иргэд олон улсын аялалаас татгалзахаар байгаа хэдий ч, Засгийн газрын дэмжлэгтэй жижиглэн худалдаачдын хоолны өдөрлөг, сэдэвчилсэн дэлгүүрүүд (themed shopping) зэрэг санаачлагуудын нөлөөгөөр өсөхөөр хүлээгдэж байна. Түүнчлэн энэхүү эерэг нөлөө нь тансаг зэрэглэлийн брендүүдийн борлуулалтыг 2-р улиралд нэмэгдүүлэх төсөөллийг Блүүмбергийн шинжээчид хийв.
- Хятадын дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой **коксжих нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ болон Хятадын эрчим хүчний нүүрсний үнэ бага түвшинд хадгалагдсан хэвээр байгааг SXCoal мэдээлэв.** Сүүлийн 2 сар дараалан буурч буй коксжих нүүрсний үнийг дэмжих хүрээнд Хятадын зарим боомтууд Австралиас авах нүүрсний импортын хоригоо чангаруулаад байгаа бөгөөд зөвхөн худалдан авагч тал гаалийн хуудас бөглөснөөр тээврийг хүлээн авах болсон билээ. Импортын хоригийн тухайд албан ёсны мэдээлэл хараахан гараагүйн дээр үргэлжлэх хугацаа нь ч тодорхойгүй байна. Мөн Засгийн газраас нүүрсний үнэ нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрүүдийг үйлдвэрлэлээ сайн дураараа бууруулахыг уриалж байна.
- БНХАУ болон АНУ хоорондын харилцаа таагүй болж буй энэ үед **Хятадын Засгийн газраас АНУ-ын 79 нэр төрлийн бүтээгдэхүүнийг импортын тарифаас 1 жилийн хугацаанд чөлөөлөх шийдвэрийг 5-р сарын 12-нд зарлалаа.**
- **Хятадын төсвийн бодлого:** Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бондын арилжаа болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авснаар 2020 онд Хятадын Засгийн газар 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийх төлөвтэй байна. Хятадын Засгийн газраас 2-6-р саруудад ойролцоогоор

650 тэрбум юанийн хөнгөлөлтийг компаниудад олгохоор байна. Хятадын Ардын Их Хурал 5-р сарын 22-ны өдрөөс эхлэн хуралдана. Тус хурлаар ДНБ-ий өсөлтийн тоон зорилтыг энэ онд цуцлах эсэх, төсвийн алдагдлын хэмжээ болон тусгай зориулалттай бонд олголтын квот зэргийг эцсийн байдлаар батлах хүлээлттэй байна. Блүүмбергийн шинжээчид 2005 оноос хойш ДНБ-ий 3 хувиас доогуур хадгалагдаж байсан төсвийн алдагдлыг /төсвийн ерөнхий алдагдал, тусгай зориулалттай бондын хэмжээг оруулаад/ 2020 онд ДНБ-ий 8-9 хувь, албан ёсны төсвийн алдагдал 3.5-3.7 хувь, бондын квотыг 1.5-2 их наяд юань, урьдчилан батлагдаад буй тусгай зориулалттай 2.29 их наяд юанийн орон нутгийн Засгийн газруудад олгох бондын квот 3.5-4 их наяд юаньд хүрнэ гэж таамаглаж байна. Хэдийгээр энэ удаагийн Ардын Их хурлаар өсөлтийн тоон зорилтыг цуцалж болзошгүй ч, илүү өргөн интервалтай буюу 3.5-4.5 хувь, нэг жилийн оронд 2020-2021 он буюу 2 жилийн хугацаатай байхаар зарлах, мөн бусад тоон зорилтууд /хөдөлмөр эрхлэлтийн хувь/-ыг оруулан онцлох хүлээлттэй байна.

- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байсан бол дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэн дотоод эдийн засагт ирэх дарамтыг саармагжуулахын тулд бодлогын хүүгээ 0.5-0.6 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байна. ХАБ 2-р сараас хойш бодлогын хүүг 0.3 нэгж хувиар бууруулж, 1 жилийн хугацаатай дунд хугацааны зээлийн хүүг (TMLF) 3.15 хувиас бууруулж, 2.95 хувьд хүргэсэн. 2-р улиралд бодлогын хүүг дахин 0.2 нэгж хувиар бууруулна

² ХАБ-аас 4-р сарын 3-нд Заавал байлгах нөөцийн хувийг 1 нэгж хувиар 2 үе шаттайгаар бууруулах шийдвэрийг гаргаж, эхний удаагийнх 4-р сарын 15-с

гэж Блүүмбергийн шинжээчид таамаглаж байна. Түүнчлэн, 4-р сарын 3-ний өдөр зарласан Заавал байлгах нөөцийн хувийг жижиг банкуудад 1 нэгж хувиар бууруулах шат дараатай бодлогын шийдвэр² 5-р сарын 15-наас хэрэгжиж эхэлснээр нийт 400 тэрбум юанийн эх үүсвэр чөлөөлөгдөв. ХАБ-наас 2-4-р саруудад 3 төрлийн дахин зээлдүүлэх квот гаргасны эхний 2 квотын нийт дүн 800 тэрбум юань байсан нь 5-р сарын эхний хагаст бүрэн зарцуулагдлаа гэж Мөнгөний бодлогын мэдэгдэлдээ мэдээлэв. Харин 3 дахь квот нь 3 сарын хугацаанд зарцуулагдах 1 их наяд юанийн квот байна. Энэ нь дахин зээлдүүлэх зорилгоор 5-7-аар саруудад сард дунджаар 330 тэрбум юанийг зах зээлд нийлүүлэхээр байна. Хятадын Ардын банкнаас олон нийтэд зарласан статистик тоон мэдээллээс харахад ЗБН-өөс давсан илүүдэл нөөцийн хэмжээ 4-р сарын эцэст 1.9 хувь байв. ХАБ нэг талдаа 2 сараас 5-р сарын эхний хагас хүртэлх хугацаанд дахин санхүүжилтийн хэрэгслүүдээрээ дамжуулан 674 тэрбум юанийг сунгаад байна. Мөн нээлттэй зах зээлийн хэрэгслүүд болох репо, дунд хугацаатай зээлийн сан болон зорилтот зээлийн сангаараа дамжуулан 381 тэрбум юанийг банкны салбараас татаад байна. 5-р сарын эцэст татварын төлбөр төлөх улирал ойртож буйтай холбоотой банкны салбараас 350 тэрбум юань татагдах төлөвтэй хэдий ч, 6-р сараас Засгийн газрын цэвэр зарцуулалт нэмэгдэхээр байгаа тул хөрвөх чадварт нөлөө бага гэж үзэж байна. Цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийг дэмжих арга хэмжээг авах хүлээлттэй байна.

хэрэгжиж эхэлсэн бол 2-р шат 5-р сарын 15-наас хэрэгжиж эхлэхээр байна.


3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ 2020 ОНЫ 5-Р САРД

Эдийн засгийн өсөлт:

2020 оны 1 дүгээр улиралд эдийн засаг өмнөх оны мөн үеэс 10.7%-иар агшив.


2019 оны 1 дүгээр улиралд бодит ДНБ-ий хэмжээ 3.5 их наяд төгрөг байсан бол энэ оны эхний улиралд 3.1 их наяд төгрөг болж 377.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Эдийн засгийн 10,7 нэгж хувийн уналтын задаргааг авч үзвэл уул уурхайн салбар -7.6 нэгж хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбар -1.3 нэгж хувь, тээвэр ба агуулахын салбар -2.1 нэгж хувь, бүтээгдэхүүний цэвэр албан татвар -1 нэгж хувийн өсөлтийг тус тус голлон бүрдүүлж байна.

Зураг 1. ДНБ-ий жилийн өсөлтөд эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Зураг 2. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өсөлт




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Боловсруулах салбарын хувьд 2020 оны 1 дүгээр улиралд 3.5%-ийн өсөлттэй гарсан байна.

Ундаа үйлдвэрлэл (согтууруулах ундаа ороод) болон кокс, шахмал түлш үйлдвэрлэл нь энэхүү өсөлтийг харгалзан 4.8 нэгж хувь болон 4.5 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн. Харин төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэлийн үйлдвэрлэл, нэхмэл болон хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтийн хурд саарсан буюу -7.1 нэгж хувийн нөлөөг үзүүлсэн байна.

Зураг 3. Уул уурхайн салбарын өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2020 оны 1 дүгээр улиралд уул уурхайн салбар -29.8% (-858 тэрбум төгрөг)-ийн өсөлттэй гарлаа.


Үүнийг задаргаагаар нь авч үзвэл уул уурхайн салбарын өсөлтөд нүүрс олборлолт -20.8 нэгж хувь, газрын тос олборлолт -5.8 нэгж хувь, металлын хүдэр олборлолт -3.2 нэгж хувийн нөлөөг үзүүлсэн байна. КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор хилийн хориг арга хэмжээ авсан, гадаад худалдааны томоохон түнш Хятад улсын эдийн засаг удааширсан, зарим нэр төрлийн түүхий эдийн зах зээлийн үнэ буурсан зэрэг нь энэхүү бууралтад нөлөөлж байна.

Гадаад худалдаа:

Гадаад худалдааны эргэлт буурч, тэнцэл алдагдалтай гарлаа.


2020 оны 5 дугаар сарын 15-ны байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1554.1 сая ам.доллар (31.8%)-аар буурч, худалдааны тэнцэл 220.1 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад экспорт 1362.7 сая ам.доллар (46.6%)-аар, импорт 191.4 сая ам.доллар (9.7%)-аар тус тус буурсан байна.

Зураг 4. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 5. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

5 дугаар сарын эхний 15 хоногт 186.2 сая ам.долларын экспорт, 194.4 сая ам.долларын импорт хийлээ. Энэ нь өмнөх сарын мөн үеийнхтэй харьцуулахад харгалзан 44% болон 33.3%-иар буурсан үзүүлэлт байна.

2020 он гарснаар зарим нэр төрлийн барааны экспортын гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс дараах байдлаар буурсан байна.

№	Барааны нэр	Экспорт		
		Тоо хэмжээ	сая \$	%
1	Зэсийн баяжмал	-67.2 мян.т	-323.5	-37.5
2	Алт	-3.1 т	-115.6	-59.0
3	Цайрын хүдэр, баяжмал	-2.1 мян.т	-14.5	-18.2
4	Чулуун нүүрс	-7.9 мян.т	-688.2	-62.8
5	Боловсруулаагүй газрын тос	-1.8 мян.баррель	-112.2	-83.5


Зээлийн тайлан

2020 он гарсаар тэтгэврийн зээлээс бусад зээлийн олголт болон эргэн төлөлтийн хэмжээ буурлаа³.

2019 оны 12 дугаар сард нийт зээлийн үлдэгдэл (тэтгэврийн зээл хассан)-ийн 11.4% буюу 1.97 их наяд төгрөгийн зээлийг эргэн төлсөн байна. Харин 2020 оны 4 дүгээр сард энэ үзүүлэлт нь 8.9% болж буурчээ.

Зээл олголтын хэмжээ 2019 оны 12 дугаар сард 1.99 их наяд төгрөг байсан бол 4 дүгээр сард 1.47 их наяд төгрөг болж 26%-иар буурсан байна.

Зураг 6. Зээлийн эргэн төлөлт, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголбанк

³ МУ-ын Засгийн газраас тэтгэврийн зээлийг тэглэсэнтэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 2020 оны 2, 3 дугаар саруудад нэмэгдсэн тул тэтгэврийн зээлийг хасаж тооцоолов.

2020 оны 5 дугаар сараас 2020 оныг дуусталх хугацаанд ипотекийн зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болсон бөгөөд Монголбанк, арилжааны банкнаас тус бүр 120 тэрбум, нийт 240 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх юм. Уг хөтөлбөрийг УИХ-аас Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын дагуу Монголбанк “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд”-д өөрчлөлт оруулан, банкуудтай гэрээ байгуулснаар хэрэгжүүлж эхэллээ.

Монголбанкнаас ипотекийн зээлийг бага, дунд орлоготой зорилтот бүлэгт чиглүүлж, хөтөлбөрийг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч байна. Үүнд:

- Монголбанкны эх үүсвэрээр нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ 100 сая төгрөгөөс дээшгүй байх;
- Монголбанкны эх үүсвэрээр олгох нийт санхүүжилтийн 25 хувиас доошгүй хувийг орон нутагт орон сууц худалдан авч байгаа иргэдэд олгох;
- Монголбанкны эх үүсвэрээр зөвхөн шинээр олгох зээлийг санхүүжүүлэх;
- Монголбанкны эх үүсвэрийн 15 хувийг төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад олгох;

- Үндсэн эсвэл хамтран зээлдэгчийн өмчлөл дэх үл хөдлөх хөрөнгийг урьдчилгаа төлбөрт барьцаалах боломж олгов.


Монголбанкнаас 2020 оны 5 дугаар сараас эхлэн ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, Хас банк, Улаанбаатар хотын банк, Богд банк, Тээвэр хөгжлийн банк, Кредит банк, Ариг банк, Капитрон банкуудад эх үүсвэр хуваарилсан бөгөөд иргэд эдгээр банкуудад хандан ипотекийн 8 хувийн зээл авах боломжтой боллоо.

Түүнчлэн, Олон улсын валютын сан (ОУВС)-гийн ажлын хэсэг 2020 оны 5 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Монгол Улсын эрх баригчидтай цахим уулзалт зохион байгуулав. Уулзалтын үеэр КОВИД-19 цар тахлын Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө, өрийн тогтвортой байдал болон бусад асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн. Улмаар, уулзалтын дараа Шуурхай санхүүжилтийн хэрэгсэлд Монгол Улсыг хамруулах хүсэлтийг хэлэлцэж, төсвийн болон төлбөрийн тэнцлийн яаралтай төлбөрүүдийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 72.3 сая зээлжих тусгай эрх буюу 99 сая ам.долларын санхүүжилт олгохоор ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрлээ. ОУВС-гаас мэдээлж байгаагаар 6-р сарын эхээр тус асуудлыг ОУВС-гийн захирлуудын зөвлөлөөр хэлэлцэж эцэслэн шийдвэрлэх юм.


5 ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

КОВИД-19 цар тахлын тархалтыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнүүд нь газрын тосны эрэлт огцом буурахад нөлөөлсөн. Газрын тосны үйлдвэрлэлийн гарцаа танах ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн хэлцэл болон зарим улсад хориг арга хэмжээг аажмаар сулруулж, газрын тосны эрэлт буцаж нэмэгдсэнээр сүүлийн 3 долоо хоногт газрын тосны үнэ сэргэж 36 ам.долларт хүрээд байна. Хятад улсад шинэ коронавирусийн тархалт буурч, эдийн засаг нь идэвхжиж, үйлдвэрүүд нь үйл ажиллагаагаа сэргээсэнтэй холбоотойгоор зэсийн ханш сүүлийн 2 сарын хугацаанд 17 хувиар өсөж 5400 ам.долларт хүрлээ. Харин Бразил улсад халдвар эрчимтэй тархсантай зэрэгцэн төмрийн хүдрийн нийлүүлэлт тасалдсанаар төмрийн хүдрийн үнэ огцом өсөж 91 ам.долларт хүрчээ. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал, эрсдэл өндөр байгаа тул алтны ханш 1700-1750 ам.долларын түвшинд хэвээр хадгалагдаж байна.

Зураг 7. Зэсийн үнэ




Зэсийн үнэ. Манай улсын гол экспортын бүтээгдэхүүнүүдийн нэг болох зэсийн үнэ КОВИД-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор огцом унасан бөгөөд 3 дугаар сарын 23-ны байдлаар 4609 ам.долларт хүрч буурсан нь сүүлийн 4 жилийн хамгийн доод түвшин юм. Харин дэлхийн зэсийн эрэлтийн тал хувийг дангаар бүрдүүлдэг БНХАУ-ын үйлдвэрүүд үйл ажиллагаагаа сэргээж, тус улсын зэсийн импорт огцом өссөнтэй холбоотойгоор сүүлийн хоёр сарын хугацаанд зэсийн үнэ аажмаар буцаж сэргэн 5400 орчим ам долларт хүрээд байна.



Алтны ханш. Дэлхийн эдийн засагт аливаа хямрал, тодорхой бус байдал үүсэхтэй зэрэгцэн алтны ханш огцом өсдөг. Үүнтэй холбоотойгоор 2020 оны эхний улиралд 6.9 хувиар өссөн нь 6 улирал дараалан алтны үнэ өссөн үзүүлэлт юм. 3 дугаар сарын эхэн үеэс Хятад улсад тархалт буурч, ихэнх улсуудын Засгийн газар, Төв банкууд КОВИД-19-ийн сөрөг үр нөлөөг бууруулах, эдийн засгаа дэмжих арга хэмжээг шийдэмгий авч эхэлснээр алтны ханш 1500 орчим ам.долларт хүрч огцом буурсан. Гэвч 4 дүгээр сараас эхлэн АНУ болон


зарим улсад вирусийн тархалт эрчимтэй нэмэгдэж, дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэхтэй зэрэгцэн алтны ханш буцаж сэргэн 1700-1750 ам.долларт хэлбэлзэж байна. Энэ нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 32 хувиар буюу 420 гаруй ам.доллараар өндөр юм.

Зураг 8. Газрын тосны үнэ



нэмэгдүүлэх шийдвэр гаргасны улмаас дэлхийн зах зээл дээр газрын тосны илүүдэл үүсэж, 3 дугаар сард газрын тосны үнэ тасралтгүй буурсан. 5 дугаар сарын 1-ээс эхлэн ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн газрын тосны гарц танах хэлэлцээр хэрэгжсэн. Мөн зарим улсууд хориг арга хэмжээгээ аажмаар сулруулсан нь газрын тосны эрэлт буцаж сэргэж эхэлсэнтэй зэрэгцэн газрын тосны үнэ өсөж 36 ам.долларт хүрлээ. Энэ нь нэг сарын өмнөх хамгийн доод түвшин 20 ам.доллартай харьцуулахад 80 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 9. Төмрийн хүдрийн үнэ



Төмрийн хүдрийн үнэ. 2019 оны 11 сараас төмрийн хүдрийн ханш тасралтгүй өссөөр 2020 оны эхний сард 95 ам.долларт хүрсэн. Дэлхийн нийтэд төмрийн хүдрийн импортын 70%-ийг бүрдүүлдэг Хятад улсад КОВИД-19-н улмаас цагаан сарын амралт урт хугацаанд үргэлжилж, аж үйлдвэрүүд зогсонги байдалд орсон нь төмрийн хүдрийн эрэлт буурахад нөлөөлсөн. Ингэснээр 2 дугаар сарын эхэнд төмрийн хүдрийн үнэ 15.3 хувиар огцом унаж 78.3 ам.долларт хүрчээ. 4 дүгээр сард төмрийн хүдрийн үнэ харьцангуй тогтвортой буюу 80-

84 ам.долларын хооронд хэлбэлзэж байсан бол Бразил улсад шинэ Коронавирусийн халдвар хурдтай тархаж, төмрийн хүдрийн нийлүүлэлтийн хувьд тодорхойгүй байдал үүсэхтэй зэрэгцэн өнгөрсөн хоёр долоон хоногт төмрийн хүдрийн ханш 11 хувиар чангарч 91.1 ам.долларт хүрлээ. Тодруулбал, Бразил улс 2019 онд долоо хоногт дунджаар 6.5 сая тонн төмрийн хүдэр экспортолдог байсан бол 5 сарын туршид 4.5 сая тонноос ихгүй төмрийн хүдэр нэг долоо хоногт экспортолсон байна.